

**МОНГОЛ УЛС, АЗИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК
ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР (МӨЧЛӨГ СӨРСӨН БОДЛОГЫН АРГА
ХЭМЖЭЭГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР)-ИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 11 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар дээрх төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцэж, дэмжсэн тухай санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд тус тус ирүүлсэн болно.


Төсвийн байнгын хорооны 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар дээрх төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй талаарх санал, дүгнэлтээ ирүүлсэн.

Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар дээрх төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Н.Ганибал, М.Оюунчимэг нар зээлийн хөрөнгөөр төсвийн алдагдал нөхөхийг дэмжихгүй гэдгээ илэрхийлж, зээлийг эргэн төлөх, ашгаа өгөх, үр дүнтэй зүйлд зарцуулах нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн болно.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар уг төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа ирэх жилийн улсын төсөв 1.5 их наяд төгрөгийн алдагдалтайгаар батлагдсан тул энэ алдагдлыг нөхөх санхүүжилтийг хэрхэн босгох талаар тодруулан асууж, хариулт авлаа.

Тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийн төслийг зөвшилцөх тухай асуудлыг дэмжсэн бөгөөд гэрээнд гарын зурах эрхийг Засгийн газарт олгох нь зүйтэй гэж үзсэн болно.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.ЭНХ-АМГАЛАН